



НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 01 сарын 14 өдөр

Дугаар А/02

Улаанбаатар хот

2016 оны өвлийн арга хэмжээний нээлтийн тухай

Монгол Улсын “Биеийн тамир, спортын тухай” хууль, Засгийн газрын 2009 оны 05 дугаар тогтоол, Засгийн газрын 2014 оны 34 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн 2016 оны зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Нийслэл, дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын ажилтан, албан хаагчдын “Эрүүл агаар Рио-2016” сэдэвт өвлийн улиралд зохион байгуулах биеийн тамир, спортын үйл ажиллагааны нээлтийн өдөрлөгийг 2016 оны 01 дүгээр сарын 30-ний өдөр Хандгайтын “Янзага” зусланд зохион байгуулсугай.


2. Өвлийн арга хэмжээний нээлтийг зохион байгуулахад шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3. Дээрх арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 6.880.000 /зургаан сая найман зуун наян мянган/ төгрөгийг Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын биеийн тамир, чийрэгжүүлэлтийн нийтийг хамарсан арга хэмжээний төсвийн зардлаас гаргахыг нягтлан бодогч /О.Эрдэнэцэцэг/-т зөвшөөрсүгэй.


4. Дээрх арга хэмжээнд Нийслэл дүүргийн нутгийн захиргааны байгууллага болон аж ахуйн нэгжийн ажилтан албан хаагч, иргэдийг өргөнөөр хамруулж, зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг ахлах мэргэжилтэн /А.Болдмаа/-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.ГАНБОЛД



Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын
даргын 2016 оны 09 сарын 24-ны өдрийн
А/02 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



2016 оны өвлийн арга хэмжээний
нээлтийн төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн /төг/
1.	Тээврийн хөлс, бензин шатахуун	100.000 төг
2.	Үзель, хөтлөгчийн хөлс	300.000 төг
3.	Анонс, урилга	400.000 төг
4.	Спорт, урлагийн үзүүлэх, тоглолт	1.500.000 төг
5.	Цом, өргөмжлөл	500.000 төг
6.	Видео бичлэг, зураг	1.500.000 төг
7.	Шагнал: 1-р байр-2 x 100.000₮ 2-р байр-2 x 80,000₮ 3-р байр-2 x 60.000₮	480.000 төг
8.	Байгууллагын шагнал: 1-р байр-1 x 500.000₮ 2-р байр 1 x 400.000₮ 3-р байр 1 x 300.000₮ 4-р байр 1 x 200.000₮ 5-р байр 1 x 100.000₮	1.500.000 төг
8.	Шүүгчдийн зардал: 15 хүн x 1 өдөр x 20.000төг	300.000 төг
9.	Гэр байрны түрээс, цайны зардал	300.000 төг
Нийт дүн		6.880.000 төг

Боловсруулсан
Хянасан

А.Болдмаа
О.Эрдэнэцэцэг